



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/1260

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
хөрөнгө хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хот тохижилтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороо, Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт байрлах хавсралтад заасан нийт 19,379,772.27 (арван есөн сая гурван зуун далан есөн мянга долоон зуун далан хоёр төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, 15,431,119.14 (арван таван сая дөрвөн зуун гучин нэгэн мянга нэг зуун арван есөн төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй 2 барилгыг тус тус акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Акталж, данс бүртгэлээс хасагдаж буй барилгыг буулгах ажлыг зохион байгуулахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг), хоёрдогч түүхий эдийн зориулалтаар үнэлэн худалдаж, худалдсанаас орох орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205515

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...12... сарын ...09... өдрийн
...1260... захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дүгнэлт
1	Диспетчерийн байр	Сонгинохайрхан дүүргийн 26-р хороо	18	13,506,386.27	3,263,628.09	10,242,758.18	Хот байгуулалт, хотын стандартын газар 2024 оны 01-07/315 тоот ирүүлсэн тайлан, Нийслэл дэх төрийн аудитын газрын асуудлыг бүртгэлийн зөрчлийн 7 жагсаалт
2	Үнс хадгалах байр	Сонгинохайрхан дүүргийн 26-р хороо	43	5,873,386.00	685,025.04	5,188,360.96	
Актлах барилга, байгууламжийн дүн				19,379,772.27	3,948,653.13	15,431,119.14	